



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/С/2

Зуунмод

Газар эзэмших эрхийг баталгаажуулж,
байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Цэлмэг хотконд иргэн Дамбадаржаа овогтой Онон /НС58123077/-ын ахуйн зориулалтаар эзэмшиж буй 300м² газар нь зам, шугам сүлжээний төлөвлөлтгэй давхцаж байгаа тул байршилыг өөрчилж Номт 1-р баг, Хуульчдын хохон 135 тоотод амины орон сууцны зориулалтаар 300м² газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Д.Ононд дараах үүргийг хариуцуулсугай.

2.1 Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2 Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах

2.3 Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх

2.4 Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2003 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 164 дүгээр захирамж болон газар эзэмших эрхийн 164442 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ



№ 001595